

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРААС  
2019 ОНЫ 08 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2019 оны 08 дугаар сарын 30

Улаанбаатар хот


Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2019 оны 08 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

**1.1. Виз, зөвшөөрөл, харьяатын чиглэлээр:**

Тайлант хугацаанд Монгол Улсад оршин суух үнэмлэх 1606 ширхгийг шинээр хэвлэн, 1731 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 33 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийн, гадаадын нэг иргэнд регистрийн дугаар олгосон байна. Үйлчилгээний танхимаар 2700 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэжээ.

Нийт 3254 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар 1338, 7585-1882 дугаарын утсаар 105, биечлэн 643, автомат хариулагчаар 1168 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Мөн Австри Улсын Вена хот дахь консулын ажилтанд утсаар виз, бүртгэлийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, есөн улсын 14 гадаадын иргэнд цахим шуудангаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна.



Цахим визийн зөвшөөрлийн хүрээнд олон улсын хилийн боомт дээрээс “J” ангиллын 581, “B” ангиллын нэг болон хоёр удаагийн орох 43 визийн зөвшөөрөл, “B” ангиллын олон удаагийн гарах-орох 208 визийн зөвшөөрөл, нийт давхардсан тоогоор 358 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч хянан, 166 аж ахуйн нэгж, байгууллагын 832 гадаадын иргэний визийн зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох хууль, журмын дагуу хянан цахимаар шийдвэрлэжээ.

Үндэсний хөгжлийн газрын дэргэдэх хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвд тус байгууллагын хоёр мэргэжилтэн ажиллаж 69 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, гадаадын 46 иргэнд визийн зөвшөөрөл, 61 иргэнд оршин суух зөвшөөрөл олгож, 95 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, 19 иргэний ангиллыг сольж, 24 иргэнд хасалт хийсэн байна. Мөн хөрөнгө оруулагчаар оршин суух зөвшөөрөлтэй 137 иргэнд зохих ангиллын виз олголоо.

2019 оны 08 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 6.9 хувиар, хувийн урилга олголт 19.4 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 4.9 хувиар өссөн, харин виз олголт 11.0 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 24.0 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 50.7 хувиар, түр ирэгчийн бүртгэл 4.7 хувиар, түр ирэгчийн хасалт 7.0 хувиар, визийн сунгалт 18.8 хувиар тус тус буурсан байна.

Иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:


Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гурван хүний хүсэлтийг хуульд заасан шалгуурыг хангаагүй тул буцаан хүргүүлэв. Мөн Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан нэг иргэний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүллээ.

Монгол Улсын харьяатаас гарч гадаадын долоон улсын харьяат болох хүсэлт гаргасан 38 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, 21 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авах ажиллагааг хийсэн.

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй таван хүний хүсэлтийг шинээр хүлээн авч, холбогдох байгууллагаас санал авах ажиллагааг хийсэн байна.

Иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй таван хүний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, мөн таван хүний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүллээ.

Хоёрдмол харьяалал үүсгэсэн 101 иргэнийг бүртгэж мэдээллийн санд оруулсан ба нийт 3394 иргэн бүртгэлтэй байна.



Тайлант хугацаанд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан зургаа, хүчингүй болгох хүсэлт гаргасан нэг олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлтийг хүлээн авсан. 2019 оны 08 дугаар сарын байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 95 төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын байна.

Гадаадын хоёр улсын гэр бүлд үрчлүүлсэн найман хүүхдийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлээ.


#### 1.2. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Тайлант хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн дөрвөн улсын 57 иргэнийг байгууллагын даргын 15 удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр байгууллагын даргын гурван удаагийн тушаалаар гадаадын гурван улсын гурван иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, хоёр удаагийн тушаалаар гадаадын нэг улсын хоёр иргэний хилээр нэвтрэх эрхийг сэргээн ажиллалаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд зааснаар 248 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн ба Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан үндэслэлээр дөрвөн улсын 23 иргэнд гарах сануулга өгч, Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн гурван захирамжаар гадаадын нэг улсын гурван иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн байранд саатуулсан.

Тайлангийн хугацаанд дөрвөн удаагийн төлөвлөгөөт, 31 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 69 аж ахуйн нэгж, байгууллага, 1571 гадаадын иргэнийг хамруулсан ба 319 гадаадын иргэн, 152 аж ахуйн нэгж, байгууллага /гадаадын 355 иргэн/, хоёр уригч иргэн /гадаадын хоёр иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 149,440,000 /нэг зуун дөчин есөн сая дөрвөн зуун дөчин мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээ.



2019 оны 08 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 10.0 хувиар, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 61.7 хувиар өссөн, харин албадан гаргагдсан гадаадын иргэн 16.2 хувиар буурсан байна.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажил, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх чиглэлээр 2016-2019 онд хийсэн ажлын тайланг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад, байгууллагын 2019 оны 07 дугаар сарын үйл ажиллагааны тоон мэдээг инфографик хэлбэрээр гарган Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргад, байгууллагын 2019 оны 07 дугаар сарын ажиллагааны тайланг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргад тус тус албан бичгээр хүргүүлэн ажиллалаа.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 65 өргөдөл, гурван гомдол ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 54 өргөдөл, гурван гомдол шийдвэрлэгдэж, 11 өргөдөл хуульд заасан хугацааны хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байгаа ба хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй.

Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоол, “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай” 277 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны 13 албан хаагчийн ангилал зэрэглэлийг шинэчлэн баталлаа.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай” 90 дүгээр захирамжаар олгосон дөрвөн албан хаагчийн төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийн нэмэгдэл хөлсийг шинэчлэн баталсан.

Мэдээлэл технологийн үндэсний паркийн инженер Б.Бямбадорж “Phyton програмчлалын хэл” сэдвээр сургалт зохион байгуулж таван албан хаагч, Нийслэлийн Онцгой байдлын газрын дэргэдэх Гамшгаас хамгаалах сургалтын төвд “Гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлыг хангах” сэдэвт сургалтад 22 албан хаагч оролцов. Түүнчлэн орон нутаг дахь газарт давхардсан тоогоор бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан хоёр удаагийн сургалтад 20 албан хаагч, бусад байгууллагаас зохион байгуулсан дөрвөн удаагийн сургалт, зөвлөгөөнд есөн албан хаагч тус тус хамрагдлаа.

Тайваний Боловсролын яамны хятад хэлний тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж, Тайваний Багшийн Их Сургуулийн Мандарин хэлний төвд суралцах болсон дөрвөн албан хаагчид зургаан сарын хугацаатай суралцах чөлөөг байгууллагын даргын тушаалаар олгож, сургалтын гэрээг байгуулсан.

“Хойд бүс дэх газарт туулах чадвар сайтай автомашин гардууллаа”, “Гадаадын иргэн, харьяатын газрын даргын урилгаар БНСУ-ын Хууль зүйн яамны Цагаачлал, шилжилт хөдөлгөөний албаны төлөөлөгчид Монгол Улсад айлчиллаа”, “БНСУ-д зорчих визний журамд өөрчлөлт орлоо” зэрэг мэдээ, сурвалжилгыг бэлтгэн хоёр сонин, 17 цахим хуудсаар олон нийтэд сурталчлан ажиллалаа.

## 2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлал, хуулийн төсөлтэй холбогдуулан агаарын хөлөг, төмөр замын бүрэлдэхүүний зорчих нөхцөлийн талаар лавлагааг тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахим шуудан /altantuya@mojha.gov.mn/-аар хүргүүлж ажиллав.

Байгууллагын даргын 2019 оны А/279 дүгээр тушаалаар байгууллагын дэргэд ажиллах “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”, А/283 дугаар тушаалаар “Архивын галын аюулгүйн журам”-ыг тус тус батлан албан хаагчдад мэдээлэл хүргүүлсэн.

Тайлангийн хугацаанд тус байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдэд шинээр томилогдохоор нэр дэвшсэн нэг, шилжин томилогдохоор нэр дэвшсэн гурван албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлж, шинээр томилогдсон гурав, их хэмжээний өөрчлөлтөө мэдүүлсэн хоёр албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажууллаа.

Байгууллагын даргын урилгаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагаачлал, шилжилт хөдөлгөөний албаны дарга Ча Гюү Гын тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад хийсэн албан айлчлалыг зохион байгуулж ажиллалаа. Айлчлалын бүрэлдэхүүн Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж болон Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар нартай уулзаж цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов. Мөн байгууллагын дарга хоёр улсын иргэд харилцан таатай зорчих нөхцөлийг бүрдүүлэх үүднээс тодорхой асуудлын хүрээнд санал солилцож, ойлголцолд хүрсэн.

Байгууллагын дарга тэргүүтэй төлөөлөгчид Тайваний Тайпэйн худалдаа, эдийн засгийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газрын дарга Хуан Куо Рун, дэд дарга Жой Янь, “Дэээрэт” олон улсын энэрлийн байгууллагын Азийн бүс хариуцсан захирал Петр Ф.Мэурс тэргүүтэй төлөөлөгчдийг байгууллага дээрээ хүлээн авч уулзан, хамтын ажиллагааны талаар санал солилцов.

## 2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Хилийн боомт, орон нутаг дахь газрын үйл ажиллагааны холбогдох мэдээ, тайланг нэгтгэн авах ReportPro, цахим архивын программ хангамжуудыг тус тус шинээр хийж холбогдох сургалтыг явуулсны үндсэн дээр байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж эхэллээ.

Мөн “E-Visa” цахим системд 2019 оны 05-аас 08 дугаар сард үүссэн мэдээллийн санг DVD-д хуулбарлан байгууллагын архивт хүлээлгэн өгсөн.

## 2.4. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2019 онд 6,27 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд өссөн дүнгээр 08 дугаар сард 4,48 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 3,78 тэрбум төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан болно.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 08 дугаар сарын байдлаар 3 тэрбум 623 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 689,4 сая төгрөгийн хүү торгуулийн орлого, 74,9 сая төгрөгийн визийн хуудасны орлогыг улсын төсөвт төвлөрүүлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020-2022 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан төсвийн төсөөллийг боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3-т заасны дагуу Сангийн яаманд танилцуулж хянуулсан.

Байгууллагын албан хаагчдын хүүхдийн цэцэрлэг байгуулахтай холбогдуулан тайлант хугацаанд тохижилт үйлчилгээнд 8,1 сая төгрөг зарцуулаад байна.

#### 2.5. Хяналт шинжилгээ, аудитын чиглэлээр:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны 2019 оны 07 дугаар сарын мэдээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын ажлын албанд, мөн сарын статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус хүргүүлсэн.

Үндсэн үйл ажиллагааны статистик мэдээллийн эмхэтгэл гаргах ажлын хүрээнд 2001-2018 оны үйл ажиллагааны статистик тоон мэдээг нэгтгэн баяжуулж, эхийг бэлтгэн, хэвлэлтэд өгөхөд бэлэн болоод байна.

Шилэн дансны тухай хуулийн 2019 оны 01-ээс 07 дугаар сарын хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг холбогдох албан тушаалтанд танилцуулж, зөрчлийг засаж залруулах талаарх заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

#### 2.6. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд заасны дагуу 113 гадаадын иргэнийг орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан ба зохих бичиг баримтын бүрдэл хангаагүй 15 гадаадын иргэнийг гарах чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан.

Монгол Улсаас хилийн чанадад суугаа Элчин сайдын яам, консулын газар, өргөмжит консулаас визийн хүчинтэй хугацаа, нэр, огноо буруу, визийн зориулалт бичигдээгүй зэрэг гадаадын 266 иргэнд олгогдсон визийг тухай бүр хуулбарлан авч, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолын дагуу визийг дахин олгон хил нэвтрүүлсэн болно.

Замын-Үүд хилийн боомтыг өргөтгөн шинэчлэх үед боомтын үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбогдуулан Сангийн яаман дээр зохион байгуулагдсан уулзалтад байгууллагын төлөөлөл оролцсон. Уг өргөтгөл шинэчлэлтийн ажлын явцад боомтын үйл ажиллагааг Замын-Үүд чөлөөт бүсэд явуулахаар болсонтой холбогдуулан зорчигч иргэдэд хүндрэл, чирэгдэл учруулахгүйгээр албаны үйл ажиллагааг явуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

